

**ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН  
ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 03 дугаар  
сарын 21-ний өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлийг Засгийн газар баталж, Улсын Их Хуралд танилцуулах, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалыг анхдагч хуулийн төсөл болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд зарчмын шинжтэй зохицуулалт оруулж байгаа хуулийн төслийг боловсруулахад ашиглах, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх аргачлалыг хасах, хуулийн төслийн төрлөөс багц хуулийн төслийг хасах, хуулийн төслийн танилцуулгыг товч болон дэлгэрэнгүй хэлбэрээр бэлтгэх, хууль санаачлагч өөрийн санаачлан Улсын Их Хурлаар батлуулсан хуулийн албан бус орчуулгыг хийх зэрэг зохицуулалтыг тусган хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн дэргэд Хууль зүйн хэлний салбар зөвлөл ажиллах тухай заалтыг өөрчилж Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн дэргэд ажиллахаар тусгаж, бүрэлдэхүүн, ажиллах журмыг Хууль зүй, дотоод хэргийн сайд батлахаар тусгасан бөгөөд төрийн байгууллагад дээрх хүний нөөцийн болон санхүүгийн тодорхой зардал үүсэхээр тооцоолол гарсан гэж хууль санаачлагч үзсэн байна.

Хуулийн төслийг D-parliament.mn цахим хуудаст байршуулан олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил батлагдсан хуулиас гадна өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийн орчуулгыг хийх эсэх, Хууль зүй, дотоод хэргийн яам болон Гадаад харилцааны яам хамтран нэгж байгуулж хуулийн албан бус орчуулгыг хийх боломж байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяа хууль санаачлах хүрээ хязгаарын талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлийг Улсын Их Хурал баталдаг байсныг Засгийн газар баталж Улсын Их Хуралд танилцуулахаар өөрчлөх болсон үндэслэл шаардлагын талаар асуулт асууж, хариулт авсан болно.


Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 72.7 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**

A large, stylized handwritten signature in black ink, written over a rectangular stamp. The signature is slanted and appears to be 'Б.ЗНХБАЯР'.

**Б.ЗНХБАЯР**